

**МОНГОЛ УЛСЫН ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ  
(ТОС)-ИЙН ЗАРЧИМ  
УУЛ УУРХАЙН САЛБАРЫН УДИРДАМЖ**

2015 оны 2–р сар

## АГУУЛГА

Нэр томъёоны тайлбар	3
1. Танилцуулга	6
2. Зорилго	6
3. Хэрэгжүүлэлт болон хамрах хүрээ	6
4. Монгол Улсын уул уурхайн салбарын байгаль орчин, нийгмийн асуудал	7
5. Монгол улс дахь уул уурхайн салбарын зээлтэй холбоотой байгаль орчин, нийгмийн шаардлага	8
6. Хяналт шинжилгээ	10
7. Тайлагнал	10
Хавсралт 1: Монгол Улсын Уул уурхайн салбарын үйл ажиллагаа, байгаль орчин, нийгмийн холбогдолтой асуудлууд	12
Хавсралт 2: Уул уурхайн салбарын БОНХ-ын холбогдолтой хууль тогтоомж	24
Хавсралт 3: Уул уурхайн салбарын холбогдох үндэсний болон олон улсын байгаль орчин, нийгмийн стандарт, шаардлага болон бусад бичиг баримт	25
Хавсралт 4: ХАА-н салбарын оролцогч талуудын үүрэг, хариуцлага	27

## Нэр томъёоны тайлбар

Товчлол/Нэр томъёо	Тодорхойлолт
Банк	Банк гэдэгт Байгаль орчин, нийгэмд ээлтэй Тогтвортой санхүүжилт (ТоС)-ийн хамтарсан тунхаг бичигт гарын үсэг зурсан Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй банкийг ойлгоно
Тэсэлгээ	Чулуулгийн тэсэлгээ нь малталт хийх, нураах, чулуулаг зайлуулах зорилгоор тэсрэх бодис болон хийн даралтат тэсэлгээний пиротехник эсхүл плазма процесс зэрэг аргуудыг тусгай хяналтан доор ашиглахийг хэлнэ (геологи). Энэ нь ихэвчлэн уул уурхайн олборлолт, элс, хайрганы карьерын ажил болон зам, далан барих зэрэг иргэний барилгын ажлын үед хэрэглэгддэг
Үндсэн ажиллагаа	үйл Банкнаас харилцагчдад үзүүлж буй санхүүгийн бүтээгдээхүүн, үйлчилгээний хүртээмж, тухайлбал, компанийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын банк (нөхцөл өөрчлөгдсөн зээл, хөрөнгө, худалдаа), өмчийн хөрөнгө оруулалт, төслийн санхүүжилт, бүтцийн худалдааны санхүүжилт, ЖДБ-ийн зээл, иргэдийн банк, худалдаа, лизинг, зээлийн бусад төрөл гэх мэт багтах бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй юм.
Дотоод ажиллагаа	үйл Банкнаас өөрийн үндсэн үйл ажиллагааг явуулахад шаардлагатай боловсон хүчин, өмч хөрөнгө болон дэд бүтэц (оффис, банкны салбар, тоног төхөөрөмж гэх мэт) багтана. Үүнд мөн банкнаас өөрийн үндсэн үйл ажиллагааг эрхлэх болон дотоод үйл ажиллагааг явуулахад хамтран ажиллаж буй ханган нийлүүлэгч, гэрээт байгууллага, гуравдагч үйлчилгээ үзүүлэгч талууд багтана.
Монгол банк	Монгол Улсын Төв банк (Монгол банк)
Нүүрс боловсруулах үйлдвэр	Нүүрс боловсруулах үйлдвэр нь хоосон чулуулгаас нүүрсийг угаан салгах, төрөл бүрийн хэмжээтэй хэсгүүдэд бутлах (ангилах), зах зээлд гаргахад бэлдэж нөөцлөх, галт тэрэг, ачааны хөлөг онгоц, усан онгоцонд ачих зэрэг үйл ажиллагааг явуулдаг байгууламж юм
Цианжуулалт	Алтны цианжуулалт нь алтыг бага агуулгатай хүдрээс усанд уусдаг комплекс болгон хувиргах замаар олборлох металлургийн арга юм. Энэ нь алт олборлоход хамгийн түгээмэлээр хэрэглэгддэг арга юм. Цианид нь маш хортой бодис учир энэхүү процессийг ашиглах нь маргаантай байдаг бөгөөд хэд хэдэн улс орнуудад хориглосон юм
Өрөмдлөг	Өрөмдлөгийн гол зорилго нь хөрс/литологийг шинжлэх явдал. Энэ нь уурхайн хүдрийн биетийг тоон үзүүлэлтээр тогтоох; барилга буюу өндөр байгууламж барихад тохиромжтой суурийг нь тодорхойлох; эсхүл хонгил, зоорь зэрэг далд байгууламжуудыг барихын өмнө тухайн газрын тухай ойлголттой болох нь газрыг хэрхэн ухах мөн тулгуур хэрхэн хийхийг тодорхойлоход маш чухал юм. Өрөмдлөгийг мөн уурхайн босоо болон налуу амны байгууламж барихад ашигладаг
Б&Н	Байгаль орчин, нийгмийн
Байгаль орчин, нийгмийн эрсдэл	Бизнес болон эрсдэлийн удирдлагын шийдвэр гаргахад анхаарах шаардлагатай байж болох, мөн эрсдэл үүсгэж болзошгүй харилцагч буюу гэрээ хэлцэлтэй холбоотой эрсдэл дагуулж магадгүй байгаль орчин, нийгмийн болзошгүй асуудлууд

Байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөлөл	Бизнесийн үйл ажиллагаа буюу банкнаас санхүүжилт авах гэж буй бизнесийн үйл ажиллагаанаас үүсэх (а) физик, байгалийн болон соёлын орчинд, түүнчлэн (b) ойр орчмын олон нийт, ажилчдад үүсэх бодит эсхүл болзошгүй аливаа өөрчлөлтүүдийг ойлгоно. Байгаль орчин, нийгмийн нөлөөллүүд нь байгаль орчин, хүн/олон нийтэд түр зуурын эсхүл байнгын шинжтэй, нөхөн сэргээгдэх эсхүл нөхөн сэргээгдэхгүй шинжтэй байж болно. Байгаль орчны нөлөөлөлд хүний үйл ажиллагаа (хүлэмжийн хий, бохирдол, амьдрах орчны өөрчлөлт гэх мэт)-наас үүдэлтэй агаар мандлын, усны, газар нутгийн өөрчлөлтүүд багтана. Нийгмийн нөлөөлөлд тухайн харилцагчийн ажиллах хүч болон ойр орчмын олон нийт (хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа эрүүл ахуй, хүний эрх болон хөдөлмөрийн стандарт, газрын маргаан/нүүлгэн суурьшуулалт, авилга гэх мэт)-эд үзүүлэх нөлөөллүүд багтана
Байгаль орчин, нийгмийн боломж	Байгаль орчин, нийгмийн асуудлуудыг шийдвэрлэхтэй холбоотойгоор үүсэх шинэ бизнесийн боломж (цэвэр/сэргээгдэх техник технологийг боловсруулах, шинэ ажлын байр бий болгох, орон нутгийг хөгжүүлэх гэх мэт)-ийг ойлгоно. Бизнесийн шийдвэр гаргахдаа байгаль орчин, нийгмийн асуудлуудыг анхааран авч үзэх нь харилцагч болон тухайн харилцагчид санхүүгийн үйлчилгээ үзүүлж буй банкинд шинэ боломж, давуу талуудыг нээн өгөх боломжтой
Экваторын зарчим	Экваторын зарчим нь төсөл санхүүжүүлэхтэй холбоотой байгаль орчин, нийгмийн эрсдэлүүдийг тодорхойлох, үнэлж, менежмент хийх тухай сайн дурын стандартуудын эмхтгэл юм
Флотацийн арга	Хөвүүлэн баяжуулах флотацийн арга нь усанд уусдаггүй материалыг усанд амархан уусдаг материалаас салгах арга юм. Энэхүү арга нь сульфидийн хүдрийг олборлох, баяжуулах цорын ганц үйл ажиллагаа бөгөөд хөвүүлэн баяжуулах флотацийн аргыг ашиглан зэс, тугалга агуулсан эрдэс зэрэг эдийн засгийн ач холбогдолтой ашигт малтмалын олборлолтыг сайжруулсан юм
ОУСК	Олон улсын санхүүгийн корпораци
БОНХЯ	Байгаль орчин, Ногоон хөгжлийн яам
МУАМГ	Монгол Улсын Ашигт малтмалын газар
МУГТГ	Монгол Улсын Газрын тосны газар
Зарчмууд	МУ-ын Тогтвортой санхүүжилт (ТоС)-ийн зарчмууд
ЖДҮ	Жижиг, дунд үйлдвэрлэл
Хандлан уусгалт – Электролизийн арга	Хандлан уусгалт – Электролизийн арга нь зэс агуулсан чулуулгийн овоолгоор нэвчүүлсэн ялимгүй хүчиллэг уснаас цэвэр зэс гаргаж авах харьцангуй энгийн арга юм
Тогтвортой санхүүжилт	Бид тогтвортой санхүүжилт гэдгийг тодорхойлохдоо МУ-ын эдийн засгийн урт хугацааны хөгжилд банкуудын гүйцэтгэх үүргийг гагцхүү санхүүгийн ашиг сонирхлоор бус байгаль орчин, нийгэмд хариуцлагатай байдлаар оролцох явдлыг хүлээн зөвшөөрдөг арга зам юм гэж үзэж байна
Хаягдлын аж ахуй	Уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн шаардлагуудыг харгалзан баяжуулах үйлдвэрийн хаягдал ба хаягдал чулуулаг хадгалах байгууламжийн зураг төсөл, барилга болон ашиглалтын үйл ажиллагааг өндөр жишигт нийцүүлэн боловсруулдаг. Байгууламжийн менежментын хамгийн оновчтой стратеги нь уурхайн талбайн онцлогт тохирсон байдаг тул байгууламжийн байршил, хаягдал зайлуулах арга, усны менежмент, уурхайн хаалтын урт хугацааны зорилт зэрэг нь нарийн тодорхойлогдсон байх шаардлагатай
Ураны олборлолт	Ураны олборлолт нь газрын гүнээс ураны хүдрийг гаргаж авах үйл явц юм. Ураны хүдрийг олборлосны дараа хүдрийг ижил хэмжээтэй жижиг хэсгүүдэд нунтаглан, хүдрээс химийн уусгагч бодис ашиглан ураныг ялгаж авдаг.

Тээрэмдэх явцдаа ураны зах зээл дээр  $U_3O_8$  гэдэг нэрээр зарагддаг байгалийн уран бүхий нунтаг хэлбэртэй шар бодисийг гаргаж авдаг

## 1. Танилцуулга

Энэхүү удирдамжийг Монгол Улсын Тогтвортой санхүүжилт (ТоС)-ийн дараах зарчмууд (Зарчим)-ын дагалдах баримт бичиг болгон уул уурхайн салбар, салбарын үйл ажиллагаанд зээл эсвэл хувьцааны санхүүжилт олгодог банкуудад зориулж боловсруулсан байна. Үүнд:

Зарчим 1 | Байгаль орчныг хамгаалах

Зарчим 2 | Ажилчид болон орон нутгийн иргэдийг хамгаалах

Зарчим 3 | Түүх, соёлын өвийг хамгаалах

Зарчим 4 | Ногоон эдийн засгийн өсөлтийг дэмжих

Зарчим 5 | Санхүүгийн үйлчилгээг хүртээмжтэй болгох

Зарчим 6 | Ёс зүйтэй санхүүжилт, компанийн засаглалыг дэмжих

Зарчим 7 | Хариуцлагатай, ил тод байдлыг дэмжих

Зарчим 8 | Манлайлан үлгэрлэх

Уул уурхайн салбарын төслийг санхүүжүүлж, харилцагчдад зээл олгож буй банкууд шинэ харилцагч, төсөл, зээлийг үнэлэхдээ Монгол Улсын Тогтвортой санхүүжилт (ТоС)-ийн зарчмууд болон энэхүү салбарын удирдамжийг мөрдөх шаардлагатай. Салбарын удирдамжийг Монгол Улсын Тогтвортой санхүүжилт (ТоС)-ийн зарчмуудад нийцэж, эдгээрийн хэрэгжүүлэлтийг дэмжсэн байхаар загварчилсан юм. Энэхүү Салбарын удирдамж нь байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлагад гол төлөв анхаарлаа хандуулсан боловч банкууд эрсдэлийн удирдлагаас гадна байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийг сайжруулах боломжийг харгалзан үзэх шаардлагатай.

## 2. Зорилго

Уул уурхайн салбарын энэхүү удирдамж нь уул уурхайн салбарын харилцагчдад зээл олгохтой холбоотойгоор үүсэж болзошгүй байгаль орчин, нийгмийн (БОНХ) эрсдэл, боломжийг үнэлэхэд нь банкуудад дэмжлэг үзүүлэх зорилготой. Удирдамжийг дараах үйл ажиллагааг дэмжих зорилгоор боловсруулсан. Үүнд:

- Уул уурхайн салбарын харилцагчийн үйл ажиллагаатай холбоотой эрсдэл, боломжийг тодорхойлохийг зэрэгцээ харилцагчийн байгаль орчин, нийгмийн асуудлуудыг (**Хавсралт 1, Хүснэгт 1**-ийг харна уу) удирдах чадварыг тодорхойлох;
- Уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой байгаль орчин, нийгмийн эрсдэлийг зээл болон харилцагчийн түвшинд үнэлж, ангилах байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээний шалгуурыг бий болгох;
- ХАА-н салбарын харилцагчдад зээл болон санхүүжилт олгохтой холбоотой үүсэх байгаль орчин, нийгмийн эрсдэлийг удирдах салбарын холбогдолтой олон улсын стандарт, тэргүүн туршлагыг авч хэрэгжүүлэх;
- Уул уурхайн салбарын харилцагчдад зээл болон санхүүжилт олгох явцдаа ил тод байдал<sup>1</sup>, хариуцлагыг дэмжих хандлагыг авч хэрэгжүүлэх;
- Шаардлагатай тохиолдолд, харилцагчийн байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийг сайжруулах боломжийг тодорхойлж эрэлхийлнэ.

## 3. Хэрэгжүүлэлт болон хамрах хүрээ

<sup>1</sup> <http://www.eitimongolia.mn/home.shtml>

Энэхүү удирдамжийг Зарчмуудыг хэрэгжүүлж буй Монгол Улсын банкууд хэрэгжүүлэх бөгөөд уул уурхайн салбарын харилцагч, хөрөнгө оруулж буй компаниудын үндсэн үйл ажиллагааг хамруулна. Удирдамжинд уул уурхайн салбарын дараах үйл ажиллагаа багтах бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй. Үүнд:

1. Хайгуулийн төсөл, хамааралтай байгууламж;
2. Метал олборлох уурхайн төсөл, хамааралтай дэд бүтэц;
3. Метал бус элемент олборлох уурхайн төсөл, хамааралтай дэд бүтэц; ба
4. Эрчим хүчний нөөц олборлох уурхайн төсөл, хамааралтай дэд бүтэц.

Дараах хүснэгтээс эдгээр гол үйл ажиллагаанд багтсан дэд салбарын үйл ажиллагааны жагсаалтыг харна уу.

Салбарын үйл ажиллагаа	Дэд салбарын үйл ажиллагаа
Хайгуулийн төсөл	
Метал олборлох уурхайн төсөл	<ul style="list-style-type: none"> <li>• Зэс болон бусад метал – ил, далд уурхай</li> <li>• Алт – ил, далд уурхай</li> <li>• Төмөр – ил, далд уурхай</li> </ul>
Метал бус элемент олборлох уурхайн төсөл	<ul style="list-style-type: none"> <li>• Барилгын материалын карьер</li> <li>• Жонш – ил, далд уурхай</li> </ul>
Эрчим хүчний нөөц олборлох уурхайн төсөл	<ul style="list-style-type: none"> <li>• Нүүрс – ил, далд уурхай</li> <li>• Шатдаг занар, газрын тосны уурхай</li> <li>• Ураны уурхай</li> </ul>

Энэхүү удирдамжинд тусгасан байгаль орчин, нийгмийн эрсдэлүүд нь уул уурхайн салбарын үйл ажиллагаатай холбоотойгоор банкны харилцагч, түүний ханган нийлүүлэгчийн үйл ажиллагаанаас байгаль орчин, орон нутгийн иргэдэд учирч болзошгүй нөлөөлөл, эрсдэлүүдэд хамааралтай. **Хавсралт 1: Уул уурхайн салбарын үйл ажиллагаа, холбогдолтой байгаль орчин, нийгмийн эрсдэл**-ийг харна уу.

#### 4. Монгол Улсын уул уурхайн салбарын байгаль орчин, нийгмийн асуудал

Уул уурхайн салбарын харилцагч, төсөлд санхүүжилт, зээл олгохдоо банк нь дараах нөхцлүүдийг харгалзан байгаль орчин, нийгмийн эрсдэлүүдийг үнэлэх шаардлагатай бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй. Үүнд:

- Уул уурхайн салбарын үйл ажиллагааны төрөл болон цар хүрээ (**Хавсралт 1**-ийг харна уу);
- Байгалийн баялаг, тусгай хамгаалалтын газар нутаг, суурин газар, түүнтэй холбоотой эдийн засгийн үйл ажиллагаа зэргийг хамаарсан уул уурхайн төслийн газарзүйн байршил; ба
- Байгаль орчинд учирч болзошгүй сөрөг нөлөөлөл (тухайлбал хөрсний доройтол, биологийн олон янз байдлын алдагдал, байгалийн нөөцийн хомсдол); эсвэл (хүний эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдалд учирч болзошгүй аюул, эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлт) нийгмийн нөлөөлөл болон бүс нутгийн соёлын өв аюулд өртөх зэрэг сөрөг нөлөөлөл (**Хавсралт 1**-ийг харна уу).

Байгаль орчин, нийгмийн зарим асуудлууд эрсдэлийн өндөр түвшинд багтана. Доорхи хүснэгтэнд өндөр, дунд эрсдэлтэй зээлийн жишээг дурьдсан байна.

Эрсдэлийн түвшин	Нэмэлт мэдээлэл
<p><b>Өндөр эрсдэлтэй</b> үйл ажиллагаанд байгаль орчин, нийгэмд их хэмжээний, олон төрлийн, үл сэргээгдэх сөрөг эрсдэл, нөлөөлөл учруулж болзошгүй дараах үйл ажиллагаануудыг хамааруулна</p>	<p>Энэхүү ангилалд уул уурхайн дараах үйл ажиллагаа багтана:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Хүхрийн хүчлийн уусмал бүхий химийн хортой бодис хэрэглэжбуй зэс, уран олборлох уурхай (уусгалтын технологи);</li> <li>2. Цианид, мөнгөн ус бүхий химийн хортой бодис ашиглаж буй алтны шороон ордын уурхай (цианжуулалтын технологи);</li> <li>3. Байгаль орчин, нийгэм, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны хангалтгүй гүйцэтгэлтэй уул уурхайн төсөл;</li> <li>4. Химийн аюултай бодис ашиглаж, аюултай хог хаягдал үүсгэх уул уурхайн төсөл;</li> <li>5. Үндэсний ач холбогдол бүхий байгалийн, соёлын өвийн ойролцоо байрлах уул уурхайн төсөл; ба</li> <li>6. Усны хомсдолтой хуурай бүсэд байрлах уурхайн төсөл.</li> </ol>
<p><b>Дунд зэргийн эрсдэлтэй</b> зээлийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгэмд орон нутгийн шинж чанартай, бага хэмжээний, нөхөн сэргээгдэх боломжтой сөрөг эрсдэл / нөлөөлөл учруулах үйл ажиллагаа багтана</p>	<p>Энэхүү ангилалд уул уурхайн дараах үйл ажиллагааг жишээ болгон орууллаа:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Нийгмийн зөрчлийн асуудалтай (бичил уурхайчдын халдлага, уурхайн компани, бичил уурхайчид хоорондын зөрчилтэй холбоотой асуудлууд) уул уурхайн төсөл;</li> <li>2. Хөвүүлэн баяжуулах технологийн химийн бодис зэрэг арай бага хориой химийн бодис ашиглаж буй уурхайн төсөл (зэсийн баяжуулах (хөвүүлэн байжуулалт) үйлдвэр); ба</li> <li>3. Монгол Улсын Хөдөлмөрийн хуулийг дагаж мөрдөх ёстой ажлын стандарт бус нөхцөлтэй гүний уурхайн төсөл.</li> </ol>

## 5. Монгол улс дахь уул уурхайн салбарын зээлтэй холбоотой байгаль орчин, нийгмийн шаардлага

Монгол Улсын Тогтвортой санхүүжилт (ТоС)-ийн зарчмуудын талаар авсан үүрэг амлалтандаа хүрэх, уул уурхайн салбарын харилцагч эсвэл зээлтэй холбоотой БОНХ-ийн асуудлыг шийдвэрлэхийн тулд банк тус бүр өөрийн БОНХ-ийн менежментийн системийг боловсруулж хэрэгжүүлнэ. Энэхүү БОНХ-ийн тогтолцоо нь уул уурхайн салбарын БОНХ-ийн эрсдэлтэй холбоотой асуудлыг тодорхойлон, үнэлж, шийдвэрлэх, байнгын мониторинг хийхэд банкинд туслах юм.

БОНМС-ийн нэг хэсэг болгон банк нь уул уурхайн салбарын үйл ажиллагааг үнэлэхдээ холбогдох зарчмыг хэрэглэх явдал юм. Ялангуяа уул уурхайн салбарын харилцагч, төсөл эсвэл зээлтэй холбоотой асуудлаар банкинд хамгийн их хамааралтай нь Зарчим 1: Байгаль орчныг хамгаалах, Зарчим 2: Ажилчид болон орон нутгийн иргэдийг хамгаалах, Зарчим 3: Түүх, соёлын өвийг хамгаалах Зарчим 4: Ногоон эдийн засгийн өсөлтийг дэмжих, Зарчим 5: Санхүүгийн үйлчилгээг хүртээмжтэй болгох, Зарчим 6: Ёс зүйтэй санхүүжилт, компанийн засаглалыг дэмжих зэрэг юм.

Гэвч доорх арга барилаар хязгаарлагдахгүй. Үүнд:



Шаардлага	Нэмэлт мэдээлэл
<p>1. Харилцагчийн (шаардлагатай тохиолдолд, гэрээт гүйцэтгэгчийн) уул уурхайн үйл ажиллагаа явуулахтай холбоотой бичиг баримт болон зөвшөөрөлд анхан шатны шалгалт хийх</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Уул уурхайн компани: компани нь төрийн холбогдох байгууллагаар гаргуулсан өөрийн гүйцэтгэгчийн тусгай зөвшөөрөл бүхий (хайгуул, олборлолт) бичиг баримтыг хариуцна (<b>Хавсралт 2 ба 3</b>-ыг харна уу);</li> <li>• Компанийн үйл ажиллагааг Хориотой жагсаалтын дагуу шалгана;</li> <li>• Даарах үе шатыг тайлбарласан ТЭЗҮ-г мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлнэ: <ul style="list-style-type: none"> <li>• Хайгуул;</li> <li>• Уурхайн төлөвлөлт;</li> <li>• Уурхайн бүтээн байгуулалт;</li> <li>• Олборлолт, боловсруулалт; ба</li> <li>• Уурхайн хаалт.</li> </ul> </li> <li>• Мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгэсэн БОНБНУ нь дараахийг багтаах бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй: <ul style="list-style-type: none"> <li>• Өөрийн үйл ажиллагаандаа хэрэглэж буй химийн бодисыг Монгол Улсад хэрэглэхийг хориглосон, хязгаарласан химийн бодисын жагсаалтын дагуу шалгах;</li> <li>• Уурхайн талбайн суурь нөхцөл байдал;</li> <li>• Нөлөөлөл бүүруулах менежментийн төлөвлөгөө;</li> <li>• Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө бүхий Байгаль орчин хамгаалах төлөвлөгөө.</li> </ul> </li> <li>• Харилцагчийн (шаардлагатай тохиолдолд, Гүйцэтгэгчийн) Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчин, нийгмийн, чанарын менежментийн бодлого, журам, бүртгэлийг шалгах (компани нь өөрийн гүйцэтгэгчийн менежментийн тогтолцоонд хариуцлага хүлээнэ).</li> </ul>
<p>2. Эрсдэлийг үнэлж ангилахдаа уул уурхайн салбарын харилцагч, зээлийн БОНХ-ийн эрсдэлийн үнэлгээний системийг боловсруулах. Үнэлгээ, ангиллалын үр дүн нь харилцагчийн БОНХ-ийн эрсдэлийн түвшинг тодорхойлж, зээл олголт, багцын менежмент болон шийдвэр гаргахад чухал юм</p>	<p>Уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой өндөр болон дунд эрсдэлийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Бүлэг 4-с үзнэ үү.</p>
<p>3. Уул уурхайн салбарын зээл БОНХ-ийн холбогдох олон улсын болон үндэсний хууль тогтоомж, стандартын шалгуурыг хангаж буй эсэхийг үнэлэх (<b>Хавсралт 2</b> болон <b>3</b>-г харна уу)</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Уул уурхайн үйл ажиллагаанаас хамааран үндэсний заавал мөрдөх хууль тогтоомж, стандарт болон олон улсын сайн дурын үндсэн стандартуудыг тодорхойлох;</li> <li>• Харилцагчийн гүйцэтгэлийг эдгээр хууль тогтоомж, стандартын дагуу дараах чиглэлээр хянана. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>• Байгаль хамгаалалын асуудал /үүгээр зөвхөн хязгаалагдахгүй/:</li> <ul style="list-style-type: none"> <li>• Байгаль орчны бохирдол;</li> <li>• Биологийн олон янз байдлын доройтол</li> <li>• Хог хаягдлын менежмент.</li> </ul> <li>• Нийгмийн хамгаалал /үүгээр зөвхөн хязгаалагдахгүй/:</li> <ul style="list-style-type: none"> <li>• Орон нутгийн иргэдэд нөлөөлөх байдал</li> </ul> </ul> </li> </ul>

Шаардлага	Нэмэлт мэдээлэл
	<ul style="list-style-type: none"> <li>• Ажилчдад нөлөөлөх байдал.</li> <li>• Орхигдолыг тодорхойлж (БОНХ-ийн хамгийн их сөрөг эрсдэл), тэдгээрийг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах.</li> </ul>
<p>4. Уул уурхайн салбарын БОНХ-ийн их хэмжээний эрсдэлтэй харилцагчийг тодорхойлж, эрсдэлийг зохицуулж, нөлөөллийг бууруулах харилцагчийн чадварыг үнэлэх</p>	<p>Харилцагчийн зүгээс авах менежмент, нөлөөллийг бууруулах арга хэмжээ:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Эрсдэлийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх;</li> <li>• Талуудыг татан оролцуулах өргөн хүрээтэй, үр нөлөөтэй механизмыг бий болгох (<b>Хавсралт 4-г харна уу</b>);</li> <li>• БОНХ-ийн болзошгүй эрсдэлийг 3-дагч этгээд хуваалцах зэрэг нөлөөлөл бууруулах арга хэмжээ авах</li> </ul>

Өндөр, дунд, бага эрсдэлийг тодорхойлж ангилахдаа дээрхи шаардлагуудыг харгалзан авч үзнэ.

Өндөр болон дунд эрсдэлтэй зээлийг зөвшөөрөхөөс өмнө банк харилцагч нь байгаль орчин, нийгмийн тодорхойлогдсон сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулсан эсэхийг шалгах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, харилцагч (гэрээт гүйцэтгэгч) өөрийн үйл ажиллагааны байгаль орчин, нийгмийн сөрөг нөлөөлөл, байгаль орчин, нийгмийн эрсдэлийн хэмжээг бууруулах ажлуудыг багтаасан зохистой менежментийн төлөвлөгөө болон журамтай эсэхийг баталгаажуулна.

Уул уурхайн салбарын харилцагчийн БОНХ-ийн гүйцэтгэл муу, хангалтгүй байгаа тохиолдолд банк нь үйл ажиллагааны буюу ажлын төлөвлөгөө боловсруулж өгөхийг хүсэж болно. Төлөвлөгөө нь хэрэгжихүйц, тухайн цаг хугацаатай нийцсэн мөн баримтжсан байна. Банк нь БОНХ-ийн тодорхойлогдсон эрсдэлүүдийг харилцагч нь бууруулж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор уг нөхцөл, тохиролцоог зээлийн хэлцэлд оруулж өгөх бөгөөд зөрчил илэрсэн тохиолдолд харилцагч гэрээг биелүүлээгүй гэж үзнэ.

Дээрх асуудлуудыг дэмжих, нөгөө талаас банкны БОНМС-ийн нэг хэсэг болгон банк тус бүр өөрийн холбогдох бизнесийн ажил үүргийн хуваарьт БОНХ-ийн эрсдэлийн менежментийг чадавхижуулах боломжуудыг эрэлхийлэх ба үүнд БОНХ-ийн эрсдэлийн сургалт, мэргэшсэн ажилтнуудыг авч ажиллуулж, сургалтанд хамруулах зэрэг асуудлууд багтана. Шаардлагатай тохиолдолд, банк нь БОНХ-ийн эрсдэлийн менежмент болон сургалт явуулах зорилгоор шаардлага хангахуйц үр чадвартай хөндлөнгийн 3-дагч талыг татан оролцуулж туслалцаа авч болно. Гэхдээ энэхүү төрлийн дэмжлэг нь банкны өөрийн дотоод чадавхийг бэхжүүлэх чиглэлээр байж болохгүй.

## 6. Хяналт шинжилгээ

Байгаль орчин, нийгмийн өндөр эрсдэлтэй уул уурхайн салбарын зээлийг батлахын өмнө банк нь тухайн компанийн байгаль орчин, нийгмийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны хүрээнд тохирсон БОНХ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөө; БОНХ-ын удирдлагын төлөвлөгөө; бусад шаардлагын хэрэгжилтэнд хяналт тавина.

## 7. Тайлагнал<sup>2</sup>

Банк нь өөрийн байгаль орчин, нийгмийн удирдлагын хэрэгжилтийн үйл явц, түршлага, уул уурхайн салбарын харилцагч, түүний зээлийн түүхийн мэдээллийг багтаасан тайланг жилд нэг удаа Монгол

<sup>2</sup> Монгол улсын банкууд тайлагналын шаардлага дээр тохирсны дараа үүнийг эргэж хянаж өөрчлөнө

банк болон Монголын банкны холбоонд ирүүлнэ (**Хавсралт 4**-г харна уу). Уул уурхайн харилцагчийн зээлийн үйл ажиллагааны тайланд дараах зүйлсийг тусгасан байна (үүгээр хязгаарлагдахгүй). Үүнд:

- Уул уурхайн салбарын үнэлсэн зээлийн тоо;
- Уул уурхайн салбарын зөвшөөрөгдсөн зээлийн тоо;
- Уул уурхайн салбарын үйл ажиллагаа, бүс нутгийн байршлаар харуулсан байгаль орчин, нийгмийн эрсдэлийн ангилал;
- БОНХ-ын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан үйл ажиллагааны явц бүхий тогтмол хяналт шинжилгээний шаардлага.

## Хавсралт 1: Монгол Улсын Уул уурхайн салбарын үйл ажиллагаа, байгаль орчин, нийгмийн холбогдолтой асуудлууд

Уул уурхайн салбар нь Монгол Улсын эдийн засагт чухал үүрэгтэй бөгөөд салбар нь 2013 онд ДНБ-ний 18.5%, экспортын бүтээгдэхүүний 88%-ийг үйлдвэрлэсэн. Цаашдаа ч, Монгол Улсын эдийн засгийн хөгжилд оруулах хувь нэмэр нь өсөх төлөвтэй байгаа. Тэгсэн хэдий ч, уул уурхайн үйл ажиллагааны идэвхижилт нь байгаль орчны хамгаалал, нөхөн сэргээлттэй холбоотой асуудлыг нэмэгдүүлж байна.

Уул уурхайн салбарын харилцагчийн үйл ажиллагаатай холбоотой БОНХ-ийн асуудлын мөн чанар, төрөл нь уул уурхайн үйл ажиллагааны төрөл, цар хүрээнд хамаарна. Уул уурхайн компанийн БОННБҮ, БОНБНҮ-д дэлгэрэнгүй дурдсан БОНХ-ийн асуудлууд, түүнчлэн БОНХ-ийн эрсдэлийн үнэлгээ, ангилалын явцад хөндөгдөөгүй асуудлыг банк харгалзан авч үзэх шаардлагатай. Харилцагч, түүний зээлийн БОНХ-ийн эрсдэлийн үнэлгээг хийхдээ уул уурхайн үйл ажиллагаа, түүнтэй холбоотой дараах БОНХ-ийн асуудлыг харгалзан үзэх ёстой. Хүснэгт 1-д үзүүлсэн БОНХ-ийн асуудлууд үүгээр хязгаарлагдахгүй гэдгийг анхаарна уу.

### Хүснэгт 1: Уул уурхайн салбарын үйл ажиллагаа, байгаль орчин, нийгмийн холбогдох асуудлууд

Уурхайн үйл ажиллагаа	Уурхайн процесс	БОНХ-ын томоохон асуудалтай гол байгууламж	Байгаль орчны гол асуудал	Хяналт	Нийгмийн гол асуудал	Хяналт
Хайгуул		<ul style="list-style-type: none"> <li>Зайнаас тандах судалгаа</li> <li>Чичирхийллийн судалгаа</li> <li>Геофизикийн судалгаа</li> <li>Өрөмдлөг</li> <li>Суваг шуудуу татах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Өрмийн машинд хэрэглэдэг химийн бодис хөрс, усыг бохирдуулах</li> <li>Газрын эвдрэл доройтол</li> <li>Агаарын бохирдол, уур амьсгалын өөрчлөлтөнд нөлөөлөх тоосжилт, дуу чимээ хийн хаягдлын асуудлууд</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Бохирдолоос урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө бүхий бохирдолын хяналтыг хэрэгжүүлэх (ус, хөрсний чанарын хяналт шинжилгээ, асгаралтын хяналтын журам зэргийг багтаасан)</li> <li>Газрын нөхөн сэргээлт</li> <li>Байгаль орчинд (экосистем, зэрлэг байгаль), агаарт хийн хаягдал, дуу чимээ, чичиргээнээс үзүүлж буй сөрөг</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Усны нөөц болон бэлчээр ашиглах боломжгүй болох</li> <li>Нутгийн иргэдийн үймээн самуун</li> <li>Байгаль, соёлын өв дурсгал алдагдах</li> <li>Хүний эрх (ажлын байрны нөхцөл, ажлын цаг, хөдөлмөрийн гэрээтэй холбоотой зөрчлүүд)</li> <li>Ажилчид болон орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдал</li> <li>Байгууламжтай холбоотой</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Алдсан эд хогшил, газрын үнийг нөхөн олгох хэлбэрээр газар, усны ашиглалтын хязгаарлалтаас үүсэх нийгэм, эдийн засгийн сөрөг нөлөөллөөс зайлсхийж, багасгах</li> <li>Нутгийн иргэдэд төслийн зүгээс үзүүлэх сөрөг нөлөөллөөс зайлсхийх, бууруулж, нөхөн олговор олгох</li> <li>Соёлын өвийг төслийн үйл ажиллагаанаас үзүүлэх сөрөг нөлөөллөөс хамгаалах, хадгалан хамгаалах, энэхүү соёлын өвийг</li> </ul>

Уурхайн үйл ажиллагаа	Уурхайн процесс	БОНХ-ын томоохон асуудалтай гол байгууламж	Байгаль орчны гол асуудал	Хяналт	Нийгмийн гол асуудал	Хяналт
			<ul style="list-style-type: none"> <li>Хог хаягдал үүсэх</li> </ul>	<p>нөлөөллөөс зайлсхийж, бууруулж, хянах</p> <ul style="list-style-type: none"> <li>Аюултай, аюултай бус хог хаягдал үүсгэхээс зайлсхийж, бууруулан Хог хаягдлын зохистой устгал, хяналт шинжилгээ бүхий хог хаягдлын менежментийн хяналтыг хэрэгжүүлэх</li> </ul>	эрсдэл	<p>ашиглаж олох ашгийг тэгш хуваахийг дэмжих<sup>3</sup></p> <ul style="list-style-type: none"> <li>Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль, Олон улсын Хөдөлмөрийн байгууллагын стандарт, хамтын гэрээ болон олон улсын Хүний эрхийн конвенцийг дагаж мөрдөх</li> <li>Хөдөлмөрийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулиудыг дагаж мөрдөх</li> <li>Нөлөөлд өртсөн нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд үзүүлэх сөрөг нөлөөллөөс зайлсхийх</li> <li>Байгууламжийн аюулгүй байдалтай холбоотой галын гол эрсдэл, хэрэглэгдэх норм, стандарт болон эрсдэл бууруулах арга хэмжээ бүхий Галын аюулгүй байдлын мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх<sup>4</sup></li> </ul>
Металлын уурхай		<ul style="list-style-type: none"> <li>Тэсэлгээ</li> <li>Бутлалт</li> <li>Хөвүүлэн баяжуулах үйлдвэр</li> <li>Уусган хандлах – Электролитийн уулмалаас</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Хүхрийн хүчил, флотацийн урвалж зэрэг химийн бодисын хэрэглээнээс үүсэх хөрс, усны бохирдол</li> <li>Газрын эвдрэл доройтол</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Бохирдолоос урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө бүхий бохирдолын хяналтыг хэрэгжүүлэх (ус, хөрсний чанарын хяналт шинжилгээ, асгаралтын хяналтын журам зэргийг багтаасан)</li> <li>Газрын нөхөн сэргээлт</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Усны нөөц болон бэлчээр ашиглах боломжгүй болох</li> <li>Нутгийн иргэдийн үймээн самуун</li> <li>Уламжлалт амьдрах хэв маяг, соёл бүхий байгаль, соёлын өв дурсгал алдагдах</li> <li>Нөлөөлд өртсөн ойр орчмын сумдын дэд бүтэц, нийтийн</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Алдсан эд хогшил, газрын үнийг нөхөн олгох хэлбэрээр газар, усны ашиглалтын хязгаарлалтаас үүсэх нийгэм, эдийн засгийн сөрөг нөлөөллөөс зайлсхийж, багасгах</li> <li>Нутгийн иргэдэд төслийн зүгээс үзүүлэх сөрөг нөлөөллөөс зайлсхийх, бууруулж, нөхөн олговор олгох</li> </ul>

<sup>3</sup> ОУСК-ын Гүйцэтгэлийн стандарт 8: Соёлын өв: [http://www.ifc.org/wps/wcm/connect/dd8d3d0049a791a6b855faa8c6a8312a/PS8\\_English\\_2012.pdf?MOD=AJPERES](http://www.ifc.org/wps/wcm/connect/dd8d3d0049a791a6b855faa8c6a8312a/PS8_English_2012.pdf?MOD=AJPERES)

<sup>4</sup> ОУСК-ийн БОЭМАА-ны удирдамж: Нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа:

<http://www.ifc.org/wps/wcm/connect/dd673400488559ae83c4d36a6515bb18/3%2BCommunity%2BHealth%2Band%2BSafety.pdf?MOD=AJPERES>

Уурхайн үйл ажиллагаа	Уурхайн процесс	БОНХ-ын томоохон асуудалтай гол байгууламж	Байгаль орчны гол асуудал	Хяналт	Нийгмийн гол асуудал	Хяналт
		<ul style="list-style-type: none"> <li>метал ялгах</li> <li>Хаягдал хадгалах байгууламж</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Агаарын бохирдол, уур амьсгалын өөрчлөлтөнд нөлөөлөх тоосжилт, дуу чимээ хийн хаягдлын асуудлууд</li> <li>Байгалийн нөөц, усны хомсдол</li> <li>Биологийн олон янз байдлын алдагдал, амьдрах орчны эвдрэл</li> <li>Хог хаягдал үүсэх</li> <li>Хаягдал чулуулаг, флотацийн хаягдлын хуримтлал үүсэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Байгаль орчинд (экосистем, зэрлэг байгаль), агаарт хийн хаягдал, дуу чимээ, чичиргээнээс үзүүлж буй сөрөг нөлөөллөөс зайлсхийж, бууруулж, хянах</li> <li>Эрчим хүч/усны хэрэглээг бууруулж, усыг эргүүлэн ашиглах, нар, салхи, ус зэрэг сэргээгдэх эрчим хүчийг ашиглах зэрэг үр ашигтай арга хэмжээг хэрэгжүүлэх</li> <li>Биологийн олон янз байдлыг бууруулахаас зайлсхийх (биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалал, хяналт шинжилгээ бүхий биологийн олон янз байдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх)</li> <li>Аюултай, аюултай бус хог хаягдал үүсгэхээс зайлсхийж, бууруулан Хог хаягдлын зохистой устгал, хяналт шинжилгээ бүхий хог хаягдлын менежментийн хяналтыг хэрэгжүүлэх</li> <li>Уурхайн татан буулгалтын</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>ахуйн үйлчилгээний байгууламж, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэх эдийн засгийн боломж хайн ирэх хүн амын шилжилт хөдөлгөөний асуудал</li> <li>Хүний эрх (ажлын байрны нөхцөл, ажлын цаг, хөдөлмөрийн гэрээтэй холбоотой зөрчлүүд)</li> <li>Ажилчид болон орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдал</li> <li>Байгууламжтай холбоотой эрсдэл</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Соёлын өвийг төслийн үйл ажиллагаанаас үзүүлэх сөрөг нөлөөллөөс хамгаалах, хадгалан хамгаалах, энэхүү соёлын өвийг ашиглаж олох ашгийг тэгш хуваахийг дэмжих <sup>6</sup></li> <li>Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль, Олон улсын Хөдөлмөрийн байгууллагын стандарт, хамтын гэрээ болон олон улсын Хүний эрхийн конвенцийг дагаж мөрдөх</li> <li>Хөдөлмөрийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулиудыг дагаж мөрдөх</li> <li>Ойр орчмын бүсийн хөгжлийг дэмжих</li> <li>Нөлөөлөлд өртсөн нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд үзүүлэх сөрөг нөлөөллөөс зайлсхийх</li> <li>Байгууламжийн аюулгүй байдалтай холбоотой галын гол эрсдэл, хэрэглэгдэх норм, стандарт болон эрсдэл бууруулах арга хэмжээ бүхий Галын аюулгүй байдлын мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх</li> </ul>

Уурхайн үйл ажиллагаа	Уурхайн процесс	БОНХ-ын томоохон асуудалтай гол байгууламж	Байгаль орчны гол асуудал	Хяналт	Нийгмийн гол асуудал	Хяналт
				дараа байнгын хадгалах хаягдлын сан байх хэлбэрээр <sup>5</sup> ашиглалтын явцад хаягдал чулуулаг, флотацийн хаягдлыг стандартын дагуу хаяж хураах		
	Алтны уурхай	<ul style="list-style-type: none"> <li>Тэсэлгээ</li> <li>Бутлалт</li> <li>Цианжуулалтын үйлдвэр</li> <li>Хаягдал хадгалах байгууламж</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Мөнгөн ус, цианид зэрэг химийн бодисын хэрэглээнээс үүсэх хөрс, усны бохирдол</li> <li>Газрын эвдрэл доройтол</li> <li>Агаарын бохирдол, уур амьсгалын өөрчлөлтөнд нөлөөлөх тоосжилт, дуу чимээ хийн хаягдлын асуудлууд</li> <li>Байгалийн нөөц, усны хомсдол</li> <li>Биологийн олон янз байдлын алдагдал, амьдрах орчны эвдрэл</li> <li>Хог хаягдал үүсэх</li> <li>Хаягдал чулуулаг, флотацийн</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Бохирдолоос урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө бүхий бохирдолын хяналтыг хэрэгжүүлэх (ус, хөрсний чанарын хяналт шинжилгээ, асгаралтын хяналтын журам зэргийг багтаасан)</li> <li>Газрын нөхөн сэргээлт</li> <li>Байгаль орчинд (экосистем, зэрлэг байгаль), агаарт хийн хаягдал, дуу чимээ, чичиргээнээс үзүүлж буй сөрөг нөлөөллөөс зайлсхийж, бууруулж, хянах</li> <li>Эрчим хүч/усны хэрэглээг бууруулж, усыг эргүүлэн ашиглах, нар, салхи, ус зэрэг сэргээгдэх эрчим хүчийг ашиглах зэрэг үр ашигтай арга хэмжээг хэрэгжүүлэх</li> <li>Биологийн олон янз байдлыг бууруулахаас зайлсхийх (биологийн олон янз байдлын</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Усны нөөц болон бэлчээр ашиглах боломжгүй болох</li> <li>Нутгийн иргэдийн үймээн самуун</li> <li>Байгаль, соёлын өв дурсгал алдагдах</li> <li>Нөлөөлөлд өртсөн ойр орчмын сумдын дэд бүтэц, нийтийн ахуйн үйлчилгээний байгууламж, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэх эдийн засгийн боломж хайн ирэх хүн амын шилжилт хөдөлгөөний асуудал</li> <li>Хүний эрх (ажлын байрны нөхцөл, ажлын цаг, хөдөлмөрийн гэрээтэй холбоотой зөрчлүүд)</li> <li>Ажилчид болон орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдал</li> <li>Бичил уурхай эрхлэгчдийн зүгээс үзүүлэх эрсдэл</li> <li>Байгууламжтай холбоотой эрсдэл</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Алдсан эд хогшил, газрын үнийг нөхөн олгох хэлбэрээр газар, усны ашиглалтын хязгаарлалтаас үүсэх нийгэм, эдийн засгийн сөрөг нөлөөллөөс зайлсхийж, багасгах</li> <li>Нутгийн иргэдэд төслийн зүгээс үзүүлэх сөрөг нөлөөллөөс зайлсхийх, бууруулж, нөхөн олговор олгох</li> <li>Соёлын өвийг төслийн үйл ажиллагаанаас үзүүлэх сөрөг нөлөөллөөс хамгаалах, хадгалан хамгаалах, энэхүү соёлын өвийг ашиглаж олох ашгийг тэгш хуваахийг дэмжих</li> <li>Ойр орчмын бүсийн хөгжлийг дэмжих</li> <li>Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль, Олон улсын Хөдөлмөрийн байгууллагын стандарт, хамтын гэрээ болон олон улсын Хүний эрхийн конвенцийг дагаж мөрдөх</li> <li>Хөдөлмөрийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай</li> </ul>

<sup>6</sup> ОУСК-ын Гүйцэтгэлийн стандарт 8: Соёлын өв: [http://www.ifc.org/wps/wcm/connect/dd8d3d0049a791a6b855faa8c6a8312a/PS8\\_English\\_2012.pdf?MOD=AJPERES](http://www.ifc.org/wps/wcm/connect/dd8d3d0049a791a6b855faa8c6a8312a/PS8_English_2012.pdf?MOD=AJPERES)

<sup>5</sup> <http://www.ifc.org/wps/wcm/connect/1f4dc28048855af4879cd76a6515bb18/Final%2B-%2BMining.pdf?MOD=AJPERES&id=1323153264157>

Уурхайн үйл ажиллагаа	Уурхайн процесс	БОНХ-ын томоохон асуудалтай гол байгууламж	Байгаль орчны гол асуудал	Хяналт	Нийгмийн гол асуудал	Хяналт
			хаягдлын хуримтлал үүсэх	<p>дүйцүүлэн хамгаалал, хяналт шинжилгээ бүхий биологийн олон янз байдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх)</p> <ul style="list-style-type: none"> <li>• Аюултай, аюултай бус хог хаягдал үүсгэхээс зайлсхийж, бууруулан Хог хаягдлын зохистой устгал, хяналт шинжилгээ бүхий хог хаягдлын менежментийн хяналтыг хэрэгжүүлэх</li> <li>• Уурхайн татан буулгалтын дараа байнгын хадгалах хаягдлын сан байх хэлбэрээр ашиглалтын явцад хаягдал чулуулаг, флотацийн хаягдлыг стандартын дагуу хаяж хураах</li> </ul>		<p>хуулиудыг дагаж мөрдөх</p> <ul style="list-style-type: none"> <li>• Нөлөөлөлд өртсөн нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд үзүүлэх сөрөг нөлөөллөөс зайлсхийх</li> <li>• Төрийн байгууллагуудтай хэлэлцэж дэмжлэг авах</li> <li>• Байгууламжийн аюулгүй байдалтай холбоотой галын гол эрсдэл, хэрэглэгдэх норм, стандарт болон эрсдэл бууруулах арга хэмжээ бүхий Галын аюулгүй байдлын мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх<sup>7</sup></li> </ul>
